

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 249 (5)

НШУС

2005

МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙ ДЭХ ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖИЙН АСУУДАЛД

Л. Норовсүрэн*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор (ScD), МУИС-ийн профессор

Түлхүүр үг: жендер, жендерийн мэдрэмж, тогтмол хэвлэл дэх эмэгтэйчүүдийн сэдэв.

Mонгол оронд өнгөрсөн зууны ерээд оны эхээр коммунист дэглэм нуран унаж, хүмүүнлэг ардчилсан нийгэмд шилжсэнээр хүний эрх, эрх чөлөөг жинхэнэ ёсоор хангах бүх талын орчин бүрэлдэж эхэлсэн билээ. Хуучин тогтолцооны үед хүний эрх, тэр дундаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийг хуульчлан баталгаажуулж, нийгэм-улс төрийн амьдралд оролцуулах, хүний хөгжлийг хангах зэрэгт хүйсийн ялгавар гаргахгүй байх зорилт ямар нэг хэмжээгээр хэрэгжиж байсныг үгүйсгэх аргагүй юм. Харин эрхийнхээ төлөө хийх тэмцэл, ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд нэн хангалтгүй байжээ.

Нийгэм, улс төрийн захиргаадан дэглэх систем задарч, чөлөөт ардчилсан тогтолцоо буй болсноор нийгмийн гишүүдээс эрхийнхээ төлөө хийх тэмцэл эрс идэвхжиж эхэлсэн нь жам ёсны хэрэг юм. Хүний эрх баталгаатай хангагдах нөхцөл бүрэлдэхийн хэрээр хүн тус бурийн эрх

чөлөөний зэрэгцээ хүйсийн тэгш эрхийн асуудал хүчтэй дэвшигдэн гарч ирсэн нь ч бас зүй тогтолт үзэгдэл мөн. Жендерийн мэдрэмж гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийг хангах, тэднийг нийгэм, улс төрийн амьдралд оролцуулах хувь хэмжээ, ялангуяа шийдвэр гаргах төвшинд жигд төлөөлөлтэй байлгах тухай асуудал юм. Түүнчилэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, тэдний хөдөлмөр, оюуны чадавхи, үнэт зүйлсийн талаарх нийгмийн үнэлэмжийг багтаасан ойлголт юм. Энэ үүднээс нь авч үзвэл монголчуудын хувьд эм хүйстний үнэлэмж эрчүүдийнхээс олон үеийн туршид доогуур байж ирсэн нь тодорхой билээ. Бүсгүй хүнийг «Үс нь урт, ухаан нь богино», «Богино жолоотон» хэмээн хэлэлцдэг нь Монголын эртний ёс заншлаас улбаатай юм. Олон зууны туршид нийгмийн гишүүдийг үнэлэх үнэлэмж болж хэвшсэн энэ үзлийг звдэж, хүйсийн тэгш байдлыг хангуулах тэмцэл бүх шатанд өрнөж байгаа нь сайшаалтай хэрэг. Гэвч хүйсийн тэгш бус байдлыг арилгах тэмцэл зөвхөн өнөөдөр л гарч ирсэн мэтээр ярьж,

бичих хандлага зонхилох болсон нь тийм ч оновчтой биш юм. Домогт Алун гүа, Озтүн эх, Мандухай цэцэн хатнаас эхпээд амьдралын гүн ухаантай, улс төрийн холч хараатай бүсгүйчүүд Монголын түүхэнд олон гарсныг бичиг зохиолд тэмдэглэн үлдээжээ. Шинэ цагийн бүсгүйчүүд ч эрдэм боловсролд шамдаж, бүтээн байгуулах үйлс хийгээд удирдан зохион байгуулах хэрэгт эрчүүдтэй мөр зэрэгцэн шамдаж байгааг бид бүхэн харж байна. Ялангуяа соёл, боловсрол, эрүүлийг хамгаалах салбар, дунд шатанд шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь хэлбэрэлтгүй нэмэгдэж иржээ.

Дэлхийн соёл, иргэншлийн түүхэнд ч эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэж алдарт бүтээлүүдийг туурвиж, авьяас мэдлэгээрээ тодорч, төр улсыг удирдаж ирсэн байна. Английн Засгийн газрыг арав гаруй жил удирдахдаа эдийн засгийн мэргэн бодлого явуулж, түүхэнд алдаршсан «Британийн хувьчлал»-ыг оновчтой зохион байгуулж, боловсрол, эрүүл мэнд, татварын тогтолцоонд эрс өөрчлөлт гаргасан «төмөр хатагтай» хэмээх Маргарет Тетчер, АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа Клинтоны засаг захиргааны гадаад бодлогыг тодорхойлж, үндэстэн бүрийн тэгш эрхийг хүндэтгэн хэрэгжүүлэх үйлсэд хүндтэй хувь нэмэр оруулсан Мадлен Олбрайт, улс орноо богино хугацаанд зах зээлийн харилцаанд зүгшрүүлж, ард түмнийхээ аж амьдралыг дээшлүүлж чадсан Латвийн ерөнхийлөгч асан Вике Грейберга, өөрийнх нь хэлснээр Ерөнхийлөгч Бушид «Оросын гадаад бодлогыг сургасан» АНУ-ын Төрийн

нарийн бичгийн дарга Кондолиза Райс зэрэг олон эмэгтэйг нэрлэж болно.

Монголын сэтгүүл зүй дэх жендерийн мэдрэмж зөвхөн өнөөдөр гарч ирсэн шинэ зүйл биш юм. Бид энэ талаар багагүй уламжлалтайг хуучин сонины шарласан хуудсууд хэлж өгдөг. Ерөөсөө Монголын сэтгүүл зүй үүссэн цагаасаа эхлэн эрх нь зөрчигдэж, хал зовлон амссан эмс охидын эрхийг хамгаалж ирсэн гэж хэлж болох юм. Монголын ууган тогтмол хэвлэлүүдийн нэг болох «Нийслэл хүрээний сонин бичиг»-т эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалсан агуулгатай нийтлэл олон байна. Түүний дотор «Шүүмжлэл» гэсэн гарчигтай зүйлд бичихдээ: «Үзвээс энэ жил хавар цагаас эхлэн Маймаа хотын газраас өдөр тутам гуч шахам эхнэр, охид Хүрээнээ өглөө бүр очоод, нар шингэсний хойно буцна. Хаана юу хийдгийг сураглаваас Зүүн сэлбийн газраа очиж сангийн юм оёно хэмээмуй.



у иddэгийг сураглаваас нэг хоёр удаа хар цай хэдэн аягыг олж ууна. Хөлс юу авдгийг асууваас ганц зэс зоостой хэмээмуй. Юунд хөлсгүй ажил дэмий хийнэ хэмээвээс албаны ёс гэнэ. Удаа бүр үзвээс чисчүү дээл өмссэн хүн нэгээхэн үзэгдэхгүй, бүгд уранхай цоорхой муу дээлтэй, гар хоосон ядуу янзын хүмүүс явна. Хэдэн удаа танин хүнээс асуувал зaisan, түшмэл, баян хөрөнгөтэй айлуудын нэг ч бүсгүй явсангүй тул сураглавал хоосон ядуугаа дарлан зовоож, өөрийн амийг тэжээх үйлдвэрийг саатуулан, баян хөрөнгөтэй гэрийн эздийг нүүр шагнаж өнгөрүүлэн, зaisan түшмэд тушаагаад дарга нарын эхнэр, охидод ам ангайж чадахгүй дор ядуу эмс охидыг санааны

зоргоор зовоож, дахин дахин боолчлон хөөж чирэгдүүлэх нь маш их бөгөөд сонсохуй дор даанч аятайхан хэрэг бус тул хэрхвээс зохих учрыг хянаж, доордын хөөрхийлэлтэй зовлонг баян тушаалтны шүтээнд хувааж олгоод, албаны хэмээх нэр зааж хөлсгүй цаг үргэлж зовоохыгоо хураамжлан хэмжээлж, улс төр хэмээгч олон албатыг хэлдэг учрыг хянаж ажаамуу. Гадаадын аль ч улсад байлдаанаас барьж авчирсан хүнийг ч энэ мэт зовоодоггүй¹ гэсэн байдаг. Үүнээс үзвэл тус сонин хүйсийн сул дорой байдлаараа ялгаварлагдан борчлогдож байгаа эмс охидын тэгш эрхийг эрж байжээ. Мөн сонинд нийтлэгдсэн «Зарим нэг жинстний явдал»

гэдэг өгүүлэлд Хүрээний хятад худалдаачид ихэс дээдэст тал засах гэхдээ зүс царай тунгалаг, бие бялдар тэгш эмс охидыг, бүр нөхөртэй хүүхнүүдийг ч хүртэл найранд дуулуулж, бүжиглүүлэх нэрээр аваачиж архи дарс, садар самуунд уруу татаж байгааг² эрс шүүмжлэн эсэргүүцж байжээ.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараа засаг төрөөс явуулсан нийгмийн бодлогын хүрээнд жендерийн тэгш бус байдлыг арилгах асуудал ямар нэг хэмжээгээр хөндөгдөж эхэлсэн байна. Юуны өмнө эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийг хуульчлан баталгаажуулсан нь том ололт болсон юм. 1924 онд хуралдсан Улсын анхдугаар Их Хурлаар баталсан

анхдугаар Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 11-д “Тус улсын харьяат ард түмэнд угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино”³ гэж заагаад уг заалтад хийсэн тайлбартаа «Европын зэргийн эзэрхэг харгис засагт улсуудад тийм ийм угсаа, шашинтан хэмээх буюу эрэгтэй, эмэгтэй хэмээх зэргээр онц ялгаварлан үзэх муу суртал байсны дээр бидний

монголын урьдын эзэрхэг харгисын үед мөн ч халхаас бусад аливаа монгол угсаатныг гадуурхан үзэх ба шарын шашнаас бусад шашныг шүтэгчдийг шоовдорлох, ялангуяа эмэгтэйчүүдийг ямагт гэрийн боол зарц болгон, онц до-

«
1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараа засаг төрөөс явуулсан нийгмийн бодлогын хүрээнд жендерийн тэгш бус байдлыг арилгах асуудал ямар нэг хэмжээгээр хөндөгдөж эхэлсэн байна.

»

ромжлон үзэх зэргийн муу суртал байсан нь хүн төрөлхтний гол ёсонд үнэхээрийн үл нийлэлцэх учир тийнхүү “тус улсын харьяат ард түмэнд угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй хэмээх ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбээс зохино” хэмээн тодорхойлон тогтоосон нь болой»⁴ гэсэн байдаг.

Үндсэн хуулийн үзэл санааг удирдлага болгон эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, нийгэм-улс төр, соёл хүмүүжлийн ажилд идэвхтэй оролцуулах талаар Монголын анхны хувьсгалт хэвлэлүүд багагүй анхаарч байжээ. «Уриа», «Нийслэлийн шинэ сонин», «Ардын эрх» зэрэг тогтмол хэвлэлүүд эмэгтэйчүүдийн эрхийг жинхэнэ ёсоор эдлүүлэх, тэднийг шинэ цагийн соёл боловсролд нэвтрүүлэх, айл гэрийн

хүндтэй гишүүн, улс орныхоо бүрэн эрхт иргэн байлгахыг эрмэлзсэн зүйл нийтэлж байлаа. Тухайлбал 1923 онд гарч байсан «Нийслэлийн шинэ сонин» сургуулийн хэргийг сайжруулах асуудлын хүрээнд эмэгтэйчүүдийн сурч боловсрох эрхийг хангах арга замын талаар чухал санал дэвшүүлж байсан бол 1924-1925 онд гарч байсан «Ардын эрх» сонин бүсгүйчүүдийн эрхийг хамгаалах, тэдний нийгэм-улс төрийн идэвхийг өрнүүлэх чиглэлээр олон өгүүлэл материал нийтэлж, эмэгтэйчүүдийг боолчлон дарлах гэсэн аливаа оролдлогтыг эрс эсэргүүцэн шүүмжилж байлаа.

«Ардын эрх» сонин эмэгтэйчүүдийг хөгжүүлэх үнэтэй санал зөвлөлгөө нийтлэхийн зэрэгцээ тэднийг сонин хэвлэлийн уншигч төдийгүй сониноор дамжуулан үзэл бодол, хүсэл эрмэлзлээ илэн далангүй илэрхийлдэг идэвхтэн бичигч болохыг уриалж байв. Үүний үрээр Янжмаа, Дашдэмбэрэл нарын зэрэг эмэгтэйчүүд бүр 1924 оноос сонины идэвхтэн сурвалжлагч болцгоосон байдаг. Эмэгтэй Дашдэмбэрэл «Ардын эрх» сонинд бичсэн «Эмс охид бид эрх чөлөөгөө здэлж, эрдэм соёлд боловсорцгооё» гэсэн гарчигтай захидал-нийтлэхдээ Монгол эмэгтэйчүүд олон үеийн туршид бий үзэг барилгүй, бичиг номонд шамдалгүй явсаар ирснийг харамсан тэмдэглээд, «тэд зөвхөн мал хариулж, мах идэхийг мэднэ. Эмэгтэйчүүдийн эрхийг хангасан здүгээ цагт эрдэмд шамдан суралцахыг олон бүгдээр онц хичээцгээ»⁵ хэмээн уриалсан байна.

Тус сонинд нийтлэгдсэн «Үүл арилж, нар мандлаа» гэсэн бичлэгт Нийслэлийн бүсгүйчүүдээс 20 гаруй эмэгтэй Монгол Ардын Намд

гишүүнээр элсэж, хувьсгалын хэрэгт оролцохыг хүсч гаргасан үйл өргөдлийг Төв Хороо талархалтайгаар хүлээн авч элсүүлсэн төдийгүй, бүсгүйчүүдийг сургаж гэгээрүүлэх ажилд онцгой анхаарч, дүрэм хэмжээ тогтоон, Төв Хорооны дэргэд «Бусгүйчүүдийн тасаг»-ийг байгуулсан тухай мэдээлж байжээ. Даширамд тэмдэг лэхэд тэрхүү Бүсгүйчүүдийн тасгийн анхны даргаар өмнө нь Москва хотод болсон Олон улсын эмэгтэйчүүдийн их хуралд оролцоод ирсэн орос, франц хэлтэй, өндөр боловсролтой Бадамжав гэдэг эмэгтэй томилогдон ажиллаж байсан ажээ. Бадамжав нь Монголын сэтгүүл зүйг үндэслэгч, нээрт эрдэмтэн Ж.Цэвээний эхнэр байсан юм. Тус сонинд бас «Эмэгтэй хүнийг доромжлон дарсан ичгүүргүй харгис Нямжав бэйсийн тухай» гэх мэт шүүмжлэлт, шог нийтлэл гарч байв.

Mонголын сэтгүүл зүйд жендерийн тэгш бус байдлыг тусгаж ирсэн байдлыг ажиллаж үзэхэд эхлээд эмэгтэйчүүдийн талаарх хуучны үзэл бодол, үнзлэлжийг гэтлэн давах, улмаар тэдний амьдарч, сурч, хүмүүжих наад захын эрхийг хангахад чиглэсэн агуулгатай нийтлэл зонхилж байжээ. Энэ үе 1913-1930 оныг хамарч байна. Үүний дараах үе буюу 1930-1990 оны хооронд эмэгтэйчүүд нийгэм-улс төрийн амьдралд идэвхтэй оролцогч, удирдах ажилтан, урлаг соёлын зүтгэлтэн, айл гэрт аз жаргал бэлэглэж, өнгө гэрэл нэмэгч, бүтээн байгуулах үйлсийн манлайлагч байхыг хөхүүлэн дэмжсан нийтлэл зонхилж байв. Энэ үед Монголын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, улс орныхоо идэвхтэй иргэд болгох, гэгээрүүлж соёлжуулах

зорилтыг сурталчлах ажлыг бие даасан хэвлэлээр шийдэж байсан нь үр дүнгээ өгсөн юм.

Сэтгүүл зүйд жөндөрийн мэдрэмжтэй хандах болсон үе жинхэнэ утгаараа 1990-ээд оноос эхэлсэн гэж үзмээр байдаг. Учир нь энэ үед Монгол оронд ардчилсан хувьсгал ялж нийгмийн амьдралын бүх хүрээнд эрс өөрчлөлт гарсаны дотор хүний эрх, эрх чөлөөг жинхэнэ утгаар нь дээдлэх нийгмийн сэтгэл зүй бүрдсэн юм.

Төрийн зүгээс ч энэ асуудалд анхаарлаа хандуулахыг даяаршиж байгаа гадаад ертөнц шаардах болов. НҮБ-ын Хүний хөгжлийн илтгэлд манай улсад эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, шийдвэр гаргах төвшний ажил үүрэг гүйцэтгүүлэх хэмжээ хангалтгүй байгааг удаа дараа анхааруулсан билээ. Түүнчлэн АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Бушийн санаачилсан буурай хөгжилтэй орнуудад тусlamж үзүүлэх Мянганы сорилтын сангийн гол шалгуурын нэгэнд эмэгтэйчүүдийн хөгжлийн асуудал багтсан байгаа. Энэ бүхнийг харгалzan иүзэж манай улс Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хороог Ерөнхий сайдаараа ахлуулан ажиллаж, төр засгийн бүх шатны удирдлагад эмэгтэйчүүдийн ажиллах хэмжээг нэмэгдүүлэх, УИХ-д жендерийн тэгш байдлыг хангах квотын механизм нэвтргүүлж, эмэгтэй гишүүдийн тоог

сонгуулиас сонгуульд шатлан нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа нь зүй ёсны хэрэг юм. Энэ талаарх олон улсын туршлага билдэнд сургамж болох ёстой. ХБНГУ гэхэд л аль тэртээх 1949 онд Бундестагид сонгогдох гишүүдийн хүйсийн тэгш байдлыг хангах хууль баталсан бөгөөд тэр цагаас хойш тус улсын хууль тогтоох дээд байгууллагад эмэгтэйчүүд ойролцоогоор 32 хувийг эзэлж ирсэн байдаг. Дэлхийн жишигийг үзвэл парламентийн гишүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь дунджаар 15 байдаг байна. Тэгвэл манай улсын их хурлын 76 гишүүнээс дөнгөж тавь нь эмэгтэй гишүүн байгаа бөгөөд энэ нь нийт гишүүдийн дөнгөж 6,5 хувь болж байгаа юм.

«
Эмэгтэйчүүдийн хөгжлийг хангах, нийгэм, улс төрийн амьдралд гүйцэтгэх үргийг нэмэгдүүлэхэд сэтгүүл зүйн оруулсан хувь нэмэр асар их бөгөөд энэ чиглэлийн асуудал Монголын сэтгүүл зүйн бие даасан чиглэл, бодит үйл ажиллагаа болж ирснийг тогтмол хэвлэлийн хуудас гэрчилдэг билээ.

»

хөгжлийг хангах, нийгэм, улс төрийн амьдралд гүйцэтгэх үргийг нэмэгдүүлэхэд сэтгүүл зүйн оруулсан хувь нэмэр асар их бөгөөд энэ чиглэлийн асуудал Монголын сэтгүүл зүйн бие даасан чиглэл, бодит үйл ажиллагаа болж ирснийг тогтмол хэвлэлийн хуудас гэрчилдэг билээ.

Манай улсад анх МАХН-ын Төв Хорооны 1925 оны 3 дугаар сарын бүгд хурлын тогтооолын дагуу гарсан «Бүсгүйчүүдийн санал» нэртэй сэтгүүлээр эмэгтэйчүүдийн хэвлэлийн эх суурь тавигджээ. Уг сэтгүүл манай эмэгтэйчүүдийг эрдэм боловсролд сургаж, улс орныхоо бүтээн байгуулах

Үйлсэд идэвхтэй оролцдог болгон хүмүүжүүлэхэд чиглэгдэж байв. Сэтгүүл 1926 оноос «Эмэгтэйчүүдийн санал», 1928 оноос «Эмэгтэйчүүдийн эрх», 1930 оноос «Ажилчин эмэгтэй» гэх мэт нэрээр гарч байгаад хожим нь өнөөгийн хүн бүхний мэдэх «Монголын эмэгтэйчүүд» нэрэн дээр тогтсон байдаг.

1930 оноос эхлэн гарч байсан «Ажилчин эмэгтэй» сэтгүүл өөрийн нийтлэлийн чанарыг сайжруулах зорилгоор «Манай сэтгүүлийг олон нийтэд ойртуульяа» гэсэн том өгүүлэл нийтэлж, түүндээ эмэгтэйчүүдийн сэтгүүлийг олон нийтийн чанартай болгож, зураг чимэглэлийг сайжруулах, жирийн олон эмэгтэйчүүдтэй холбоо тогтоож, тэднээр сэтгүүлээ хүрээлүүлэх зорилго тавьж байгаагаа мэдэгдсэн байна. Тус сэтгүүлд анагаах ухааны эмнэлгийг сурталчлах зорилгоор мэргэжлийн эмчийн бичсэн, элдэв өвчин үүсэх шалтгаан, урьдчилан сэргийлэх арга зэргийг тусгасан нийтлэг өгүүллүүд, бүсгүйчүүдийг соёлжуулах төв болсон клуб, улаан гэрийн тухай, эх нялхсын эрүүл мэндийг хамгаалж, зөвлөлгөө өгөх газар байгуулагдсан тухай, Эрүүлийг хамгаалах яамны дэргэд нээгдсэн сувилагч нарын курсэд эмэгтэйчүүдийг элсүүлж байгаа зэрэг олон материал нийтэлж байсан нь эмэгтэйчүүдийн хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Тэдгээрээс «Ажилчин эмэгтэй» сэтгүүлд нийтлэгдсэн нэг өгүүлэл онцгой анхаарал татаж байна. «Улсыг удирдах хэрэгт ажилчин эмэгтэйчүүд оролцох хэрэгтэй» гэсэн гарчигтай уг өгүүлэлд засаг захиргааны дарга нарыг сонгох компанийд эмэгтэйчүүдийн хүчийг өргөн оролцуулахын

чухлыг зааж «Захиргааны дарга нэрын 50 хувь, дээд тушаалын удирдах ажилцуудын 20-иос доошгүй хувьд эмэгтэйчүүдийг сонгуулах»⁶ санал дэвшүүлж байжээ. Энэ баримт нь жендерийн тэш байдлыг удирдлагын төвшинд хангах асуудлыг зөвхөн өнөөдөр ярьж эхэлсэн бич болжыг харуулж байна. Улс тэр, бизнесийн хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар өнөөгийн хүрээн төвшин, хэрэгжүүлэхээр зэхж байгаа ажил нь манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс олон арван ажил явуулж ирсэн тэмцлийн зүй ёсны үр дүн юм.

H ийт хүн амынх нь 51,6 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг манай орны хувьд аливаа ажил, асуудалд энэрэнгүй, ажил хэрэгч, аяду зөвлөн хандаж чаддаг, хүнлэг бус үйлдэл, муу зуршилд бага автагддаг эмэгтэй улс төрчдийн тоог нэмэгдүүлэх явдал нь хүмүүнлэгийн хувьд ч, нийгмийн төлөөллийг зохистой хангах шаардлагын хувьд ч нэн чухал билээ. Ингэхээр жендерийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлэх нь нийгмийн хөгжлийн бодит шаардлагаар дэвшигдэж байгаа зорилт юм.

Ишлэл

¹ "Нийслэл хүрээний сонин бичиг". 1915. №12

² "Нийслэл хүрээний сонин бичиг". 1915. №3

³ БНМАУ-ын Үндсэн хууль. УБ. 1924.

⁴ БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн тайлбар. УБ, 1924

⁵ "Ардын эрх". 1924. №4

⁶ "Ажилчин эмэгтэй" сэтгүүл. 1930. №19

1. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тойм. УБ.
2. 1998. Монгол улсын Үндсэн хуулиулд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд. (1924-1992) УБ.
3. 1964. Монголын сэтгүүлчдийн анхдугаар Их хурлын материал. УБ.
4. 1971. Утга зохиолын хөгжлийн асуудлууд. УБ.
5. 1996. Хэвлэл мэдээлэлтэй холбоотой хууль зүйн заалтууд. УБ.

Here, in this article, we have analyzed an issue of reflecting the gender inequality in the periodicals of Mongolia, using the concrete examples, and determined its present situation and future tendency.

Also, from this article, you will be acknowledged about the persistent and insufficient role of Mongolian women in the fields of education and culture as well as in the social position and decision-making process, directed to eliminating the gender inequality.